



“ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ” ОНӨААТУГ



ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2020 он

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН**ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

2.1 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, АЛБАН ДААЛГАВАР, НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ:

2.1.1 МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд.....2-3

2.1.2 МУЗГ-ын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд.....3-4

2.1.3 МУ-ын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, МУЗГ-ын 2020 оны 64 дүгээр тогтоол,
УОК-ын 2020 оны хурлын шийдвэр, НЗД-ын 2020 оны А/108, А/166, А/191, А/223 дүгээр захирамж,
НОК-ын 2020 оны хурлын тэмдэглэл, НТҮГ-2020 оны 1/251 тоот мэдэгдлийн хэрэгжилтийн
хүрээнд.....4-5

ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**3.1 БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ
МЭДЭЭЛЭЛ:**

3.1.1 Төлөвлөгөө тайлангийн хэрэгжилт, үр дүн заалтын хүрээнд.....5-10

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1 Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд.....10-11

ТАВДУГААР БҮЛЭГ: БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1 Үндсэн үйл ажиллагаанаас бусад хэрэгжүүлсэн ажлын хүрээнд.....11-12

- “ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ” ОНӨААТҮГ-ЫН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

- Дотоод хяналт шалгалтын хэлтэст хяналтад авагдсан заалт байхгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН


2.1 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН
ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

Тусгагдсан зорилт: 2.1.1 МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангана.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Дотоод хяналт шалгалтын хэлтсээс 2020 онд хяналт шалгалт хийх ажлын хүрээнд

- “Тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд”
- “Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд”
- “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал”
- “Бусад ажлын хүрээнд” гэсэн 4 чиглэлээр 27 заалт бүхий хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэн, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн стандартыг хангаагүй мөн дээд газраас ирсэн тушаал шийдвэрийг зөрчсөн нийт 28 зөрчил илрүүлэн, зөрчил арилгах, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох 39 зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг хангуулсан. Үүний үр дүнд байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт хангагдаж, ажилтнуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, дотоод хяналтын тогтолцоо сайжирсан.
- Мөн 2020 онд халдварт Коронавируст халдварт цар тахал гарч улс орон даяар үе шаттай хөл хорио, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулж төлөвлөгөөт зарим хяналт шалгалтын ажлууд хойшлогдсон.

Шалгалтуудаар илэрсэн зөрчлийг нийтлэг байдлаар нь 4 ангилж өмнөх онтой харьцуулан график болон хүснэгтээр харуулбал:



| № | Зөрчлийн төрөл | 2019 | 2020 | 2019 онд нийт зөрчилд эзлэх хувь | 2020 онд нийт зөрчилд эзлэх хувь |
|-------------|-------------------------------------------------------------|-----------|-----------|----------------------------------|----------------------------------|
| 1 | Коронавирусээс сэргийлэх заавар зөвлөмжийг зөрчсөн | | 21 | | 75% |
| 2 | Албан тушаалын тодорхойлолтоор заагдсан үүргээ баримтлаагүй | 29 | 3 | 59,2% | 10,7% |
| 3 | Хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн | 2 | 1 | 4% | 3,5% |
| 4 | Бусад холбогдох хууль, дүрэм журам зөрчсөн | 6 | 3 | 12,3% | 10,7% |
| Нийт | | 37 | 28 | 100 | 100 |

Дээрх хүснэгт графикт дүн шинжилгээ хийхэд нийтлэг гарч байгаа зөрчил дутагдлууд өмнөх оныхоос 50,6 хувиар буурсан байна. Тодруулбал:

- ✓ 2020 онд Коронавирусын цар тахал гарч үүнтэй холбоотой дүрэм журмыг тогтмол мөрдөж байгаа боловч зорчигчдоос шалтгаалсан халдвар хамгааллын дэглэм зөрчигдөх тохиолдол гарч байна
- ✓ АТТ-д заагдсан үүргээ баримтлаагүй 48,5 хувиар буурсан
- ✓ Хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн 1,6 хувиар буурсан
- ✓ Бусад холбогдох хууль, дүрэм журам зөрчсөн хувиар буурсан үзүүлэлт гарсан.

Хүрсэн үр дүн: Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 100 хувь хийж, тогтоолын хэрэгжилт хангагдсан.

Тусгагдсан зорилт: 2.1.2 МУЗГ-ын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангана.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд "Байгууллагын соёл, дэг журмыг сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх" ажлыг зохион байгуулах тухай ажлын хүрээнд Коронавируст халдвараас урьдчилсан сэргийлэх ажилтай хамтруулан захирлын баталсан ДХШХ-20/02 дугаарт удирдамжуудыг батлуулан хяналт, шалгалтын

ажлыг зохион байгуулсан. Шалгалтаар ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй бөгөөд 1, 2 дугаар баазын засварын граж, сэлбэгийн агуулах, граш, оффиссын өрөөнүүд, хурлын заал, ажилчдын цайны газар, угаалга, Нэгтгэлийн ажлын өрөөнүүд, Удирдлагын байр зэрэг бүх объект ажлын байрыг хамруулан үзлэг шалгалт хийж үйл ажиллагаандаа мөрдлөг болгох зөвлөмжийг хүргүүлсэн.

Хүрсэн үр дүн: Тогтоолын хэрэгжилт хангагдсан.

Тусгагдсан зорилт: 2.1.3

а. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар зарлиг,

б. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 30, 01 дүгээр сарын 31-ны 39, 02 дугаар сарын 12-ны 62, 02 дугаар сарын 19-ний 64 дүгээр тогтоолууд,

в. Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 01, 02 дугаар сарын 26-ны 02 дугаар тогтоолууд, 2020 оны 01 дүгээр сарын 24-ны 1, 01 дүгээр сарын 30-ны 2, 02 дугаар сарын 05-ны 3, 02 дугаар сарын 10-ны 4, 02 дугаар сарын 20-ны 5, 02 дугаар сарын 24-ны 6, 02 дугаар сарын 26-ны 7 дугаар хурлын шийдвэрүүд,

г. Нийслэлийн засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны А/108, 02 дугаар сарын 06-ны А/166, 02 дугаар сарын 07-ны А/168, 02 дугаар сарын 13-ны А/191, 02 дугаар сарын 26-ны А/223 дугаар захирамжууд,

д. Нийслэлийн онцгой комиссын даргын 01 дүгээр сарын 25-ны 01, 02 дугаар сарын 06-ны 02 дугаар тушаал,

е. Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 06-ны 01, 01 дүгээр сарын 25-ны 02, 02 дугаар сарын 12-ны 3, 02 дугаар сарын 17-ны 04, 02 дугаар сарын 22-ны 05, 02 дугаар сарын 27-ны 06 дугаар хурлын тэмдэглэл,

ё. Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/251 тоот мэдэгдэл зэрэг дээд газраас ирсэн албан бичгүүдийн хэрэгжилтийг хангана.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Цаг үеийн шинжтэй нөхцөл байдлаас шалтгаалан “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан арга хэмжээ зохион байгуулах ажилд хяналт шалгалт хийх” зорилтын хүрээнд 20/02, 20/03, 20/10 дугаарт удирдамж боловсруулан байгууллагын захирлаар батлуулан, биелэлтийг ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Тус хяналт шалгалтын ажлыг ДХШХ-ийн ажилтан Б.Ганзориг, Н.Халиунаа, Ч.Мөнхтөр, нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэв. Удирдамжид тусгагдсан зорилтын хүрээнд “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын захиргаа болон 1, 2 дугаар баазын ажилчин, албан хаагчид, ажлын байр, бүх объект, хөдлөх бүрэлдэхүүнийг хамруулан шалгалтыг 2020.03.13-ны өдрөөс эхлэн ажлын 5 хоногт зохион байгуулж 11 зөрчил илрүүлж, 3 санал хүлээн авсны дагуу 6 төрлийн зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг хянан шалгаж, ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ ОНӨААТҮГ|ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС

тайлан бичиж ажилласан байна. Хяналт шалгалтын ажлын А4-ийн 22 нүүр үндсэн тайлан, зөрчил арилгуулах тухай зөвлөмж А4-ийн 2 нүүр, зөвлөмжийн биелэлтийн хариу тайлан шалгасан тухай илтгэх хуудас А4-ийн 4 нүүр бэлтгэн боловсруулж Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна.

Хүрсэн үр дүн: Тогтоолын хэрэгжилт 100% хангагдсан.

Тусгагдсан зорилт: 2.1.4 Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 178 дугаар тогтоол, Улсын онгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 12-р тогтоол, Нийслэлийн онгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 03/6381 дугаар шийдвэр, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 дугаар захирамж зэргийн хэрэгжилтийг хангана.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол улсад “Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хяналт шалгалт зохион байгуулах тухай “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цэндийн баталсан ДХШХ-20/10 дугаарт удирдамжид тусгагдсан 7-н заалтын дагуу хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн байна. Тус хяналт шалгалтыг “Нэгтгэл, 1, 2 дугаар баазууд, хэлтэс албадын шинэ коронавируст (ковид19)-ээс урьдчилан сэргийлэн ажиллаж байгаатай холбогдуулан гаргасан тушаал шийдвэр, удирдамж, судалгаа тайлан, мэдээ мэдээллүүдийг хамруулан баримт бичгийн болон бодит нөхцөл байдлын хүрээнд явуулж 10 зөрчил илрүүлж, ажилтан албан хаагчдаас 6-н төрлийн санал, хүсэлт хүлээн авснаар 13-н төрлийн зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Хүрсэн үр дүн: Тогтоолын хэрэгжилт хангагдан ажиллаж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1 БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ:

Тусгагдсан зорилт: 3.1.1 Байгууллага болон ажилтнуудын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж ажиллана.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Дотоод хяналт шалгалтын хэлтсээс хэлтэс, алба нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт хийж, гүйцэтгэлийг дүгнэдэг бөгөөд 2020 онд нийт 12 удаагийн хяналт, шалгалтын ажил зохион байгуулж, үүрэг даалгаврын хэрэгжилт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн стандартыг хангаагүй нийт 28 зөрчил, дутагдлыг илрүүлэн, холбогдох хэлтэс, алба, албан тушаалтанд үйл ажиллагаандаа тусган ажиллах 39 зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлсэн.

тайлан бичиж ажилласан байна. Хяналт шалгалтын ажлын А4-ийн 22 нүүр үндсэн тайлан, зөрчил арилгуулах тухай зөвлөмж А4-ийн 2 нүүр, зөвлөмжийн биелэлтийн хариу тайлан шалгасан тухай илтгэх хуудас А4-ийн 4 нүүр бэлтгэн боловсруулж Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна.

Хүрсэн үр дүн: Тогтоолын хэрэгжилт 100% хангагдсан.

Тусгагдсан зорилт: 2.1.4 Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 178 дугаар тогтоол, Улсын онгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 12-р тогтоол, Нийслэлийн онгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 03/6381 дугаар шийдвэр, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 дугаар захирамж зэргийн хэрэгжилтийг хангана.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол улсад “Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хяналт шалгалт зохион байгуулах тухай “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цэндийн баталсан ДХШХ-20/10 дугаарт удирдамжид тусгагдсан 7-н заалтын дагуу хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн байна. Тус хяналт шалгалтыг “Нэгтгэл, 1, 2 дугаар баазууд, хэлтэс албадын шинэ коронавируст (ковид19)-ээс урьдчилан сэргийлэн ажиллаж байгаатай холбогдуулан гаргасан тушаал шийдвэр, удирдамж, судалгаа тайлан, мэдээ мэдээллүүдийг хамруулан баримт бичгийн болон бодит нөхцөл байдлын хүрээнд явуулж 10 зөрчил илрүүлж, ажилтан албан хаагчдаас 6-н төрлийн санал, хүсэлт хүлээн авснаар 13-н төрлийн зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Хүрсэн үр дүн: Тогтоолын хэрэгжилт хангагдан ажиллаж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1 БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ:

Тусгагдсан зорилт: 3.1.1 Байгууллага болон ажилтнуудын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж ажиллана.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Дотоод хяналт шалгалтын хэлтсээс хэлтэс, алба нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт хийж, гүйцэтгэлийг дүгнэдэг бөгөөд 2020 онд нийт 12 удаагийн хяналт, шалгалтын ажил зохион байгуулж, үүрэг даалгаврын хэрэгжилт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн стандартыг хангаагүй нийт 28 зөрчил, дутагдлыг илрүүлэн, холбогдох хэлтэс, алба, албан тушаалтанд үйл ажиллагаандаа тусган ажиллах 39 зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлсэн.

Тайлант хугацаанд хэлтэс, албадын үйл ажиллагаанд хийгдсэн нийт 11 удаагийн хяналт шалгалтаас төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн 7 шалгалт, цаг үеийн шинжтэй болон төлөвлөгөөт бусаар 4 шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Дэлхий нийтэд шинэ төрлийн Коронавирусын халдвар тархаж Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, Нийслэлийн засаг дарга, Нийтийн тээврийн үйлчилгээний газруудаас гаргасан тушаал, шийдвэр, тогтоолууд гаргасны хүрээнд 2 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулан ажиллаж 21 зөрчил, дутагдлыг илрүүлэн байгууллагын захирлуудын зөвлөлийн хуралд танилцуулан 19 зөвлөмж хүргүүлэн хариу тайлан авч зөрчлийг арилгуулан ажиллаа.
2. Зорчигч тээврийн нэгтгэлийн Ажилчдын орон сууцны захиалга, барилгын ажлын явцад хийгдсэн хяналт шалгалтаар 3 зөрчил илрүүлэн, 1 зөвлөмж хүргүүлэн ажилласан.
3. “Зорчигч тээврийн нэгтгэл”-ын 1, 2 баазуудад туршилтын хугацаанд ажиллуулсан “Цахилгаан автобус”-ны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар 4 зөрчил илэрч, цаашид засаж сайжруулах 3 зөвлөмж хүргүүлсэн.
4. Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн үйл ажиллагаанд хийгдсэн 2 удаагийн хяналт шалгалтын явцад нийт 11 зөрчил, дутагдлыг илрүүлэн, холбогдох албан тушаалтанд танилцуулж зөрчил арилгах, үйл ажиллагаандаа тусган ажиллах 6 зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлэн хариу тайланг авч ажиллаа.
5. Санхүү бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хийгдсэн 2 удаагийн хяналт шалгалт хийснээс 20/01 дугаарт шалгалт СБХ-т аудитын хяналт шалгалт явагдсаны улмаас хийгдээгүй, 20/09 дугаарт удирдамжийн явцад зөрчил, дутагдал илрээгүй.
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн албаны үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын ажил тус алба нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох дүрэм, журмын дагуу ажиллаж байгаа хэдий ч шалгалтын явцад зөрчил, дутагдлыг илрүүлээгүй боловч үйл ажиллагаандаа тусган ажиллах 2 зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлэн хариу тайланг авч ажиллаа.
7. 1, 2 дугаар баазын жолооч, шалгагч нарын ажлын байранд хийсэн үзлэг шалгалтаар зөрчил илрээгүй боловч үйл ажиллагаандаа тусган ажиллах 3 санал хүргүүлэн ажилласан.
8. Техник технологийн хэлтэс, Тээвэрлэлт үйлчилгээний хэлтсээс гаргасан удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээнд хийсэн хяналт шалгалтын явцад зөрчил, дутагдал илрээгүй боловч цаашдын халдвар хамгааллын дэглэм барьж ажиллах 4 зөвлөмж хүргүүлсэн.

Дээрх хяналт шалгалтын тайлангуудыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зөрчлийг арилгуулахаар зөвлөмжийг хүргүүлж, хариу тайланг хүлээн авч биелэлтийг хянан ажиллаа.

Мөн дотоод хяналт шалгалтаар хэлтэс, албадад өгөгдсөн зөвлөмжийн биелэлтэд тусгайлан хяналт шалгалтын ажил зохион байгуулан зөвлөмжийн хэрэгжилт болон судалгаа тайлан, санал асуулга баримт бичиг зэрэгт дүн шинжилгээ хийж ажилласан.

Хяналтын операторуудын үйл ажиллагааны талаар




- 2020 онд Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-н 1, 2 дугаар баазын тээврийн хэрэгслийн стандарт хангалтад давхардсан тоогоор нийт 1620 зөрчил байна. Үүнээс 1-р бааз дээр 1010, 2-р бааз дээр 610 зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчлүүдийг ангилан авч үзвэл дараах байдалтай байна.



Дээрх зөрчлүүдээс харахад 1, 2 дугаар баазын ихэнхи зөрчлийг суудлын бүс бүслээгүй, утсаар ярьсан зөрчил эзэлж байна.

1-р бааз дээр 2020 оны 1-р улирлын байдлаар зөрчлийн тоо 342, 2-р улиралд 228, 3-р улиралд 214, 4-р улиралд 226, 2-р бааз дээр 1-р улиралд 210, 2-р улиралд 164, 3-р улиралд 142, 4-р улиралд 94 зөрчил гарч буурсан үзүүлэлттэй байгаа нь зөрчлийг тухай бүрт арилгах шаардлага тавих мөн холбогдох албан тушаалтанд шуурхай мэдээлж, уялдаа холбоотой ажилласны үр дүн харагдаж байна. Зөрчлийг 4 улирлаар харуулбал:

Зөрчлийг 4 улирлаар харуулбал:



- Мөн 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Нийтийн тээврийн газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар, Улаанбаатар Смарт ХХК-тай хамтарсан удирдамжтай шалгалт явуулж 1, 2 дугаар баазын нийт тээврийн хэрэгсэлд суурилуулсан камерын ажиллагаа, түүний бүрэн бүтэн байдлыг шалгасан. Үүнээс онлайн системд нэвтэрсэн 218 даевоо автобусны хяналтын камерын ажиллагааг 1, 2 дугаар баазаар авч үзвэл:
- 1 дүгээр баазын 149 даевоо автобуснаас SD карт алга болсон - 10, SD карт гэмтэлтэй - 12, өнцөг өөрчилсөн - 7, камерын масстай - 3, камерын гэмтэлтэй - 4 автобус байна.
- 2 дугаар баазын 69 даевоо автобуснаас SD карт тавигдаагүй - 8, SD карт алга болсон - 22, SD карт гэмтсэн - 4, өнцөг өөрчилсөн - 7, камер масстай - 1, камерын гэмтэлтэй - 7, засварт байгаа 4 автобусыг орж шалгаагүй болно.

| | SD Карт суурилуулаагүй | | SD Карт гэмтэлтэй | | SD Карт алга болсон | |
|-----------------------------|------------------------|------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| | 1-р бааз | 2-р бааз | 1-р бааз | 2-р бааз | 1-р бааз | 2-р бааз |
| Зөрчлийн тоо | 2 | 8 | 12 | 4 | 10 | 22 |
| Зөрчилтэй тээврийн хэрэгсэл | | 02-076 02-089 02-099 02-110 02-118 02-126 02-131 02-138 | 01-005 01-023 01-071 01-074 01-135 01-013 01-049 01-057 01-069 01-085 01-034 01-126 | 02-075 02-100 02-135 02-079 | 01-047 01-010 01-025 01-026 01-037 01-078 01-099 01-104 01-129 01-145 | 02-072 02-077 02-084 02-086 02-094 02-095 02-101 02-106 02-107 02-108 02-109 02-112 02-113 02-114 02-116 02-117 02-120 02-124 02-127 02-132 02-133 02-136 |

- 2020 оны байдлаар камер шүүлгэх талаар холбогдох байгууллага, иргэнээс ирсэн 81 албан бичиг, хүсэлтийн дагуу камеруудыг шүүж 75 автобусны бичлэгийг хуулбарлан өгсөн байна.

Хүрсэн үр дүн: Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 100 хувь хийж, хэрэгжилт хангагдсан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**4.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд**

Тусгагдсан зорилт: Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, хяналт шалгалт хийх, дотоод аудит хийх, эрсдлийн удирдлагаар хангах хүрээнд.

Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд МУ-ын ЗГХЭГ даргын 2017.12.15-ны өдрийн 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн дагуу иргэд зорчигчдоос байгууллагын үйл ажиллагааны талаар тандалтын судалгаа хийнэ.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: МУ-ын ЗГХЭГ даргын 2017.12.15-ны өдрийн 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн дагуу иргэд зорчигчдоос байгууллагын үйл ажиллагааны талаар тандалтын судалгаа хийлгэхээр төлөвлөгөөнд тусгагдсан.

- Дотоод хяналт шалгалтын хэлтэс нь сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилладаг “Ололт амжилт” ХХК-тай хамтран зөвлөх шинжээч Н.Очирбат, Л.Бямбаа нараар 2020 оны 07 сарын 30-аас 09 дүгээр сарын 30 хүртэл байгууллагын үйл ажиллагаанд ажлын байрны эрсдэлийн үнэлгээ, зөвлөгөө өгч ажиллаа. Дээрх хугацаанд алдаа дутагдал, зөрчлийг илрүүлэх, ажлын байрны ажиглалт хийх, баримт бичгийн шинжилгээ хийх зэргээр ажилласан бөгөөд 5-н төрлийн зөвлөмж хүргүүлсэн болно.
- Хэлтсийн хяналт шалгалтын тайлан мэдээг холбогдох хэлтэс, албанд танилцуулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар тогтмол хамтран ажиллаж байна.
- Хэлтсийн дүрэм, журам болон бусад мэдээ, мэдээллийг байгууллагын сайт болон самбарт байршуулан мэдээлж байна.
- Хэлтсийн даргын үүрэг даалгаврын дагуу 240 автобусыг хяналтын операторууд нэг хүнд 48 автобус оногдохоор хуваарилан авч, 2020.01.23-2020.02.10-ны хооронд 24/48-р ээлжинд орж ажилласан.

Тус хугацаанд хуваарилж авсан автобуснуудад суурилуулсан камерын системийн доголдол болон DVR төхөөрөмжид тохиргоо хийж гэмтэл илэрсэн тохиолдолд SMART ХХК-д мэдэгдэн засварлуулж, 1-р баазын 150 автобусанд DVR төхөөрөмж суурилуулах явцад SD картгүй үлдсэн 94 автобусанд SD картыг хийж дуусгасан.

- Улаанбаатар Смарт ХХК-тай хамтарч 1-дүгээр баазын 149, 2-р баазын 66 автобусанд түлш хэмжигч тавьж нийт 215 автобусанд суурилуулаад байна.
- Онлайн хяналтын системд холбогдсон 217 автобуснаас 2020.01.22-ны байдлаар 81 автобус буюу 40 хувь нь онлайнд бүрэн ажиллаж байсан тул Улаанбаатар Смарт

ХХК-д мэдэгдэж дуудлага өгч тохиргоо болон нэмэлт засвар хийлгэж 109 автобус буюу 50 хувьтай онлайнд харагддаг болсон.

- 2020 оны 1 дүгээр улиралд Улаанбаатар Смарт ХХК-д 50 удаагийн дуудлагаар давхардсан тоогоор 186 автобусанд гарсан камерын доголдол, эвдрэл гэмтлийг засварлуулсан.
- 2020.03.11-ний өдрөөс эхлэн цахим хяналтын системийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Улаанбаатар Смарт ХХК-тай хамтран ажлын хэсэг байгуулан 3 долоо хоногийн хугацаатайгаар гэрээний дагуу 220 deawoo, 20 маз хөдлөх бүрэлдэхүүнд суурилуулсан камер болон түлш хэмжигчийг бүрэн ажиллагаанд оруулан хүлээлцэн ажиллаж байна.

2020 оны байдлаар Камер шүүлгэх талаар холбогдох байгууллага, иргэнээс ирсэн 81 албан бичиг, хүсэлтийн дагуу камеруудыг шүүж 75 автобусны бичлэгийг хуулбарлан өгсөн.

2020.03.23-ны өдрийн байдлаар 1, 2 дугаар баазын 220 deawoo автобус цахим хяналтын системд 98% хянагдаж, 2 дугаар баазын 20 маз автобусанд хяналтын камер суурилуулан цахим системд оруулахаар ажиллаж байна. Тус хугацаанд хуваарилж авсан автобуснуудад суурилуулсан камерын системийн доголдол болон DVR төхөөрөмжид тохиргоо хийж гэмтэл илэрсэн тохиолдолд SMART ХХК-д мэдэгдэн засварлуулж, 1-р баазын 150 автобусанд DVR төхөөрөмж суурилуулах явцад SD картгүй үлдсэн 94 автобусанд SD картыг хийж дуусгасан.

Хүрсэн үр дүн: Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө заалтын дагуу хэрэгжилт хангагдсан.

ТАВДУГААР БҮЛЭГ: БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. Үндсэн үйл ажиллагаанаас бусад хэрэгжүүлсэн ажлын хүрээнд

- 2020 онд хөтлөгдсөн баримт бичгүүдийг зааврын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн хугацаанд нь архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.
- Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан гаргасан Нийслэлийн засаг даргын захирамж, УОК-ын шийдвэрийн дагуу Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 8, 14, 15 дугаар хороодын нутаг дэвсгэрт эргүүл жижүүрийн ажлыг хэлтсийн хүн тус бүр 3 удаа хийж гүйцэтгэв.
- “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын ажилчдын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг спортын 5-н төрөлт тэмцээнд хэлтсийн ажилчид идэвх санаачилгатай оролцсон.
- Нийслэлийн ЗДТГ-с ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж Захирлын зөвлөлийн хуралд танилцуулсан.

Дүгнэлт:

Тус хэлтэс нь 2020 онд 4 чиглэлээр 27 заалт бүхий хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний биелэлтийг 76,1 хувийн гүйцэтгэлтэй ханган ажилласан. 2020 онд хэлтэс, албадын үйл ажиллагаанд хийгдсэн нийт 12 удаагийн хяналт шалгалтаас төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн 7 шалгалт, цаг үеийн шинжтэй болон төлөвлөгөөт бусаар 4, тодорхой шалтгааны улмаас хийгээгүй 1, нийт 12 шалгалтыг хийж гүйцэтгэн, хууль, тогтоомж, үүрэг даалгаврын хэрэгжилт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн стандартыг хангаагүй, Коронавируст халдвараас сэргийлэх заавар зөвлөмж зөрчсөн нийт 28 зөрчил, дутагдлыг илрүүлэн, холбогдох хэлтэс, алба, албан тушаалтанд үйл ажиллагаандаа тусган ажиллах 39 зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлэн ажиллаа. 2020 онд дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахдаа байгууллагын нэгж тус бүрийн тайлант хугацааны ажилд үнэлэлт өгөх, түүврийн арга ашиглан ажилтнуудыг хамруулсан асуулга, судалгаа авах, дүн шинжилгээ хийх, ярилцлага хийх зэрэг онцлог ажлуудыг хэрэгжүүлж, асуулга судалгааны үр дүнд ажилчдаас ирүүлсэн шинэ санал, санаачлагыг үйл ажиллагаандаа тусгах, зөрчил дутагдлыг арилгах талаар холбогдох хэлтэс, албадад зөвлөмжийг хүргүүлж, хариу тайланг хүлээн авч биелэлтийг хянан, үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. Цаашид тус хэлтэс нь удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу төлөвлөгөөт болон цаг үеийн шинжтэй хяналт шалгалтыг Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хүрээнд зохион байгуулж, байгууллагын үйл ажиллагааны зорилтыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэн, нийт ажилчдыг соён гэгээрүүлэх, эрсдлийн удирдлага, хяналт болон засаглалын тогтолцооны үр ашигтай байдлыг үнэлэх, сайжруулахад чиглэсэн зорилт, зорилгуудыг бий болгох, цаашид боловсронгуй болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллана.

ХЯНАСАН:

ДХШХ-ИЙН ДАРГА

Д.ОТГОНСҮРЭН

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ДХШ-ИЙН АЖИЛТАН

Б.ГАНЗОРИГ

Н. Халиунаа

Н.ХАЛИУНАА

Ч. Мөнхтөр

Ч.МӨНХТӨР